



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 2/19

Арвайхээр сум


**Тендерийн гүйцэтгэчийг сонгох,  
дахин тендер зарлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль-ийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар зөвлөмжийн дагуу хоол хүнсний материалын тендерийн 1 дүгээр багц сүү, сүүн бүтээгдэхүүнийг 18,200,000 (арван найман сая хоёр зуун мянган) төгрөгөөр Бурхийн рашааны ундарга хоршоогоор гүйцэтгүүлсүгэй.

2.Дээрх шалгарсан багцад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх), гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Ерөнхий санхүүч (Т.Ганчөдөр) нарт даалгасугай.

3.Нэг ч оролцогч оролцоогүй 2 дугаар багц мах, махан бүтээгдэхүүн, 3 дугаар багц гурил, гурилан бүтээгдэхүүн, 4 дүгээр багц шош будааны төрөл, 5 дугаар багц хуурай бүтээгдэхүүн, 6 дугаар багц хүнсний ногоо, 7 дугаар багц хүнсний нарийн ногоо, 8 дугаар багц жимс, жимсэн бүтээгдэхүүн, 9 дүгээр багц хүнсний туслах бүтээгдэхүүнийг тус тус нээлттэй тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Аззаяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  ДАШЖАНЦАН

